



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 00 өдөр

Дугаар А/38

Номгон


Аймгийн 2023 оны төсвийн сар, улирлын
хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйл 60.1.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.7 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” 12/55 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2023 оны төсвийн орлогын төлөвлөгөөний сар, улирлын хуваарийг нэгдүгээр, орон нутгийн сангууд, орон нутгийн төсвийн байгууллагуудын төсвийн зарлагын сар, улирлын хуваарийг хоёрдугаар, сумдад олгох санхүүгийн дэмжлэгийн сар, улирлын хуваарийг гуравдугаар, Сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн сар, улирлын хуваарийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Төсвийг хуваарийн дагуу санхүүжүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Санхүү, Төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т, төсвийн сар, улирлын хуваарийг баримтлан, батлагдсан төсвийн хүрээнд төсвийг үр ашигтай зарцуулахыг сумын Засаг дарга, орон нутгийн төсвийн байгууллагын дарга, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

642310099